**ХЭНТИЙ АЙМАГ**
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР**
**ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 07 сарын 04 өдөр Дугаар 79 Хэрлэн сум

Э.Бат-Эрдэнийг төрийн жинхэнэ
албаны нөөцөд бүртгэх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.1.1, 46.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.4, 3.1.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Геодези, зураг зүй, инженер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбаатарын Бат-Эрдэнэ нь удаан хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлэх шаардлагаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тул төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсүгэй.

2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу Э.Бат-Эрдэнийг нөөцийн бүртгэлд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА Ж.ГАНТУЛГА

Хэнтий аймгийн Төрийн
албаны салбар зөвлөлд.

Өргөдөл гаргах
учир нь

Эрдэнэбаатар овогтой Бат-Эрдэнэ миний бие нь Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэмжэст геодези зураг зүй, гектенер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаад эрүүл мэндийн шалтгааны улмаас 2019 оны 01 дүгээр сарын 27-ний өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн тул Э.Бат-Эрдэнэ миний биеийг Төрийн албаны нөөцийн бүртгэлд бүртгэж авна уу?

Өргөдөл гаргасан
Эрдэнэбаатар овогтой
Бат-Эрдэнэ.

# ХЭНТИЙ АЙМГИЙН
# ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
# ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 24 өдөр Дугаар Б/05 Хэрлэн сум

Э.Бат-Эрдэнийг ажлаас
түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1.Газрын удирдлагын хэлтсийн Геодези, зураг зүй, инженер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбаатарын Бат-Эрдэнэ нь биеийн эрүүл мэндийн улмаас ажлаа үүргээ гүйцэтгэх боломжгүй удаан хугацаанд эмчлүүлэх шаардлагатай болсон тул 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс үүрэгт ажлаас нь түр чөлөөлсүгэй.

2.Э.Бат-Эрдэнэтэй холбогдох тооцоог хийж, ажлыг хүлээлцүүлэхийг Газрын удирдлагын хэлтсийн дарга /Ц.Билэгсайхан/-д, Ерөнхий нягтлан бодогч /С.Ариунжаргал/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Д.Уламбаяр/-т даалгасугай.

ДАРГА Д.БАЯРХҮҮ